



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2016 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/64

Улаанбаатар хот


Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9, 4 дүгээр хэсгийн 4.4.15 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэл хотын Зуслан ногоон бүсийн цэвэрлэгээг 2016 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн Бямба гарагт зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Т.Батбаяр/-т үүрэг болгосугай.

2. Зуслан ногоон бүсийн цэвэрлэгээнд шаардагдах зардлын задаргааг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 3,550,000.00 /Гурван сая таван зуун тавин мянган/ төгрөгийн санхүүжилтийг хот тохижилтын бусад зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Булган/-д зөвшөөрсүгэй.



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2016 оны 05-р сарын ... өдрийн ... дугаар
тушаалын хавсралт



ЦЭВЭРЛЭГЭЭНД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ЖАГСААЛТ

№	Бүтээгдэхүүн	Тоо, хэмжээ	Нэгж үнэ /төгрөг/	Нийт дүн
1	Ажлын бээлий, хос	2500	450	1,125,000
2	Шатахуун		500,000	500,000
3	Шуудай	3500	550	1,925,000
	Нийт дүн			3,550,000